

## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

1. БСГ-ын хүсэлтээр аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулиудад Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаарын тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-хэрэгжилтийг шалгахад /сурагчийн улирлын амралт болон онцгойлон хүндэтгэх шалтгаанаар хичээллээгүй байсан хугацаанд багшид албан тушаалын үндсэн цалинг олгоно. Энэ хугацаанд багш өөрөө хүсвэл ээлжийн амралтаа урьдчилан эдэлж болно./ 2014 оны сурагчийн амралтаар 53,7 сая төгрөгийн нэмэгдэл цалин олгосон зөрчил илэрч 2015 оны цалингаас нэмэгдэл цалинг олгохгүй болсон.
2. Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2013 оны сүүлийн хагас жил, Суурь боловсролын сургуулийн 2014 оны 10-12-р сар, Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааг Цагдаагийн газарт шилжүүлэв.